

**"БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХК**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ТОГТООЛ**

2026 оны 3 сарын 18 өдөр

Дугаар: 26/01/02

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ**  
**ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2.1, 2.3 дахь заалтууд, компанийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Блюскай секьюритиз ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 13 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төвийн 5-р давхарт 502 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4-р сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэцүүлэхээр баталсугай. Үүнд:
  1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
  2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
  3. Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
  4. Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх
  5. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
  6. Бусад.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 3-р сарын 23-нд өдөр тутмын сонин, радио телевизийн аль нэгээр болон МХБ-ийн сайтаар; 2026 оны 4-р сарын 10-нд уг зарыг давтан, 2026 оны 3-р сарын 28-ны дотор брокерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цагаар тасалбар болгосугай.
6. Ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ны агуулгыг Хавсралт 1-р, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 2-р, хурлын дэгийг Хавсралт 3-р тус тус баталсугай.
7. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг 2026 оны 4-р сарын 05 өдөр гэхэд бэлэн болгож, хувьцаа

эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Г.Оюунболд/-т даалгасугай.

8. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг компаниас гаргуулсугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г.Оюунболд, гишүүнээр, Г.Халиунаа, Тооллогын комиссийн Ц. Батболд, гишүүнээр Д.Чулуунбаатар нарыг тус тус томилсугай.
10. “Блюскай секьюритиз УЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-д хүргүүлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ХАЛИУНАА



“Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн ТУЗ-ийн  
2026 оны 3-р сарын 18 өдрийн 26/01/02 тоот тогтоолын Хавсралт 02

**Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн танилцах  
бичиг баримтын жагсаалт**


1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө;
3. Бусад

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох бичиг баримттай 2026 оны 4-р сарын 05-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 11<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд дараах компанийн хаягаар ирж танилцах боломжтой.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөө

Утас: 94153555

И-мэйл: bskysec1@gmail.com



Блюэскай секьюритиз ҮЦК" ХК-ийн ТУЗ-ийн  
2026 оны 3-р сарын 18-өдрийн 26/01/02 тоот тогтоолын Хавсралт 03

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг**

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/
1.	Хувьцаа эзэмшигчид хурлын танхимд цуглах, ирц бүртгэх /ажлын хэсэг/	15
2.	Хурлын ирцыг мэдээлэх /ажлын хэсэг/	3
3.	Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж хурлаар хэлэлцэх асуудлууд хурлын дэгийг танилцуулна	10
4.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг дараалалын дагуу танилцуулан асуудал тус бүр дээр санал аван санал шүүмжлэлийг сонсох	45
5.	Хурлын завсарлага	5
6.	Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах	5
7.	Хурлаас гарах хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр тогтоолыг уншиж танилцуулах	10
8.	Хурлын дарга хурлыг хаах	3
9.	Бусад	5

Хурал зохион байгуулах комисс





“Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн ТУЗ-ийн  
2026 оны 3-р сарын 18 өдрийн 26/01/02 тоот тогтоолын Хавсралт 01

### “БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

“Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 13 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Худалдааны гудамж, Дельта төв 5-р давхар, 502 тоот өрөөнд болно.

Хувьцаа эзэмшигчийн овог: ..... нэр: .....

Регистрийн дугаар: .....

Санал өгөх хувьцааны тоо: .....

Бүртгэсэн: .....

/Үнэт цаасны компанийн нэр/

Брокерийн овог: ..... нэр: .....

№	Санал өгөх асуудал	Зөвшө өрсөн	Таггал зсан	Түтгэл зсэн
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах			
2	Компанийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах			
3	Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах			
4	Нэмэлт хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх			
5	Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнах			
6	Бусад			

Брокер ..... /гарын үсэг, тамга/

Хувьцаа эзэмшигч ..... /гарын үсэг/

#### Санал авах хуудсыг ашиглах санамж

- Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
- Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болон даалгаврын гэрээний хамт өгч явуулна.  
Таныг төлөөлөх хүний овог: ..... нэр: .....  
Оршин байгаа газрын хаяг: .....  
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 94153555 утсаар лавлаж болно.  
Саналын хуудсыг хүчингүйд тооцсон шалтгаан:.....